



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА
Т.ЖАМБААЖАМЦ ТАНАА

2026. 09. 18 № 62

**Банк бус санхүүгийн салбарын
нөхцөл байдлын талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн салбарын судлаач, Баянзүрх дүүргийн иргэн Б.Ганбаярын хүсэлтийг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх хэсгийн дагуу 2022-2026 онуудад банк бус санхүүгийн байгууллагуудад хийсэн хяналт шалгалт, түүний үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу олон нийтэд мэдээлдэг санхүүгийн тайланд хяналт шалгалт хийсэн эсэх;

3.Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн хэмжээ 2025 онд 7.2 их наяд төгрөгт хүрч, түүнээс чанаргүй зээлийн эзлэх хувь 8.4 хувь байна. Үүнээс чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 36.07 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байгаад Санхүүгийн зохицуулах хороо эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх, тийм бол эрсдэлийг ямар түвшинд гэж үнэлж байгаа талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.НАРАНБАЯР



1006000180

2026000182